



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2018 оны 9 сарын 12 өдөр

Дугаар 303

Улаанбаатар хот

┌ Дүрэмд өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх тухай ┐

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.12.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 266 дугаар тогтоолоор баталсан “Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах, бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тухай журам”-ын 3.10 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “МИК Актив Нэг – Тав ТЗК” ХХК-ийн дүрмийн 2.2.7, “МИК Актив Зургаа – Арван зургаа ТЗК” ХХК-ийн дүрмийн 2.3.7 дахь заалтыг “Мөнгөн хөрөнгийг Засгийн газрын болон төв банк, хуулийн этгээдийн үнэт цаас худалдан авах, худалдах, шалгуур хангасан банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах” гэж өөрчлөхийг зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан зөвшөөрлийг олгосонтой холбогдуулан компанийн дүрэмд өөрчлөлт оруулж Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэн энэ тухай Санхүүгийн зохицуулах хороонд ажлын 15 хоногийн дотор мэдэгдэхийг “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

3. Тогтоол батлагдсантай холбогдуулан хөрөнгө оруулагч, харилцагчдын хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлж ажиллахыг “МИК ОССК” ХХК /Б.Гантулга/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Ариунаа/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

E:\ajil 2018\Blank\Togtool.doc

000676